

VI. Угсаатны зүй, түүхэн хүн ам зүй, түүхэн социологи

МОНГОЛЧУУДЫН АН АМЬТНЫГ ХАЙРЛАН ХАМГААЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛААС

Л.Чулуунбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Энэ өгүүлэлд эртнээс монголчууд байгаль орчноо, түүний дотор ан амьтныг хайрлан хамгаалж ирснийг товч авч үзнэ. Өгүүлэлд, ан амьтныг хайрлан хамгаалах бодит шаардлага, учир холбогдлыг тэмдэглээд, чоно, цагаан зээр, тарвага, үхэр огодой зэрэг амьтдаар төлөөлүүлэн зэрлэг ан амьтдын тухайд гол төлөв харилцан шүтэлцээ, ач холбогдлыг нь уламжлалт ёс, зан заншлын дагуу товч өгүүлэхийг зорьсон болно. Байгаль, ан амьтныг хамгаалах гэдэг нь угтаа хүн төрөлхтөн өөрийгөө хамгаалж буй хэрэг юм. Энэ нь эцсийн эцэст хүн төрөлхтний оршин байхын нэг тулгуур үндэс билээ.

Түлхүүр үг: Адгуус, байгаль, ивээл, тусламж, ирээдүй

Өнөөгийн дэлхий дахинд нийт улс үндэстэн, ард түмнүүдийн сэтгэлийг зовоосон тулгамдсан олон асуудлын нэг нь байгаль экологийн хүндрэл бэрхшээлтэй шууд холбогдож байна. Ялангуяа сүүлийн 20 гаруй жилийн турш дэлхийн цаг уурт ихээхэн өөрчлөлт гарч дулааралтын улмаас хуурайшилт үлэмж болж ус чийгийн дутагдлын харгайгаар ган, гандуу байдал зонхилж газрын хөрсний үржил шим бууран өвс ургамлын зүйлийн бүрэлдэхүүн ядуурч иржээ. Энэ нь хүмүүсийн ахуй амьдралд хортой нөлөө үзүүлсэн төдийгүй, зэрлэг ан амьтан оршин байхад ч тун хэцүү нөхцлийг бүрдүүлж байгаа билээ. Монгол оронд хур тунадасны олон жилийн дундаж өөрчлөлт нь мөн нийт ургамлын нөмрөг, төрөл зүйлүүдийн баялаг байдал болон төрөл зүйлд нөлөөлсөн байна. /1:9/ Байгалийн ийм өөрчлөлт улам гүнзгийрэхэд манай хүмүүсийн үйл ажиллагаа бас тодорхой хэмжээгээр нэрмээс болсон гэхэд нэг их хилсдэхгүй болов уу. Тухайлбал, бэлчээрийн талхдал, хот суурин газрын хөрсийг бараг орвонгоор нь эргүүлсэн, атаршуулж орхисон талбай, ойт хээрийн түймэр, олон наст ургамал тариалдаггүй, усжуулалт муу зэрэг олон дутагдлыг энд дурдаж болно. Иймээс манай оронд газрын төлөв байдлын доройтол үргэлжилж байгаа юм. Ерөнхий утгаараа, газрын төлөв байдлын доройтол гэдэг нь ихэнхдээ хүний үйл ажиллагааны уршгаар газрын тодорхой зорилгоор ашиглагдах чадвар алдагдаж, чанар нь өөрчлөгдөхийг хэлдэг. /1:18/ ажээ. Энэ бүхнээс үндэслэж, эх болсон газар дэлхийгээ хамгаалах явдал бол хүн төрөлхтний, түүний дотор монгол хүн бүрийн ариун үүрэг мөн билээ. Байгаль хамгаалалтай холбоотой асуудал нь асар өргөн хүрээтэй, олон талтай учраас энэ удаа бид байгалийг бүрэлдүүлэгч амин мандлын нэг төрөл болох зэрлэг ан амьтныг хэрхэн хамгаалж ирсэн түүхэн уламжлалын тухайд зарим санаа бодлоо илэрхийлэхийг зорьсон юм. Байгаль бол сав шимийн ертөнцийн үүсэл, хөгжлийн явцад бүрэлдэн буй болсон иж бүрдэл цогц тогтолцоо билээ. Газар дэлхий, хөрс ургамал, ус унд, ан амьтан, ер дутуу зүйл энэ байгальд үгүй бөгөөд хүмүүс байгалийн бүтээлийг мөнхийн хэмээн нэрлэдэг.

Монгол орны хөрс ургамал, ус хужирт идээшин зохицсон зэрлэг ан амьтан байгалийн аль ч бүсэд оршиж байсан нь эрт үеэс хүмүүсийн агнуурын гол зүйл болсон ажээ. /2:289/ Эртний үеийн ан агнуур нь хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд үлэмж хохирол учруулдаг эрсдэл ихтэй, аз туршсан хэрэг байвч амьдрахын төлөө тэмцэл тасралтгүй үргэлжилж иржээ. Чухам тэр үеэс байгалийн нөөц баялагийг хүмүүс хэрэглэгч аж ахуйн хэлбэрээр цөлмөн ан амьтны нутагшил байршлыг алдагдуулж нөхөн үйлдвэрлэгдэх явцад нь багагүй

саад болж байжээ. Ан амьтныг хайрлан хамгаалах анхны бодит шаардлага өнө эртнээс үүссэн гэж үзэж болох авч ухамсар бодлоготой хандах хүртэл урт удаан хугацаа өнгөрсөн бололтой юм.

Харин монгол орны байгаль цаг уурт гойд дасан зохицсон амьтдаас хүмүүс гаршуулан малжихын үндэс суурь тавигдсаныг 4500 гаруй жилийн тэртээгээс нүүдлийн мал аж ахуй үүссэн гэж үздэг. Эрдэмтдийн судалснаар, "нүүдлийн мал аж ахуй бол байгаль хамгаалах нэгэн арга", байгальтай зохицон амьдрах хамгийн эртний бөгөөд үр ашигтай хэлбэр болсон байна. Ялангуяа ховор, ховордсон амьтны үнэт сан хөмрөг болсон нутгийн дархлагдсан амьтдын генофондыг ашиглаж хожмоо нарийн ноост хонь, ашиг шим өндөр үүлдэр угсааг гарган авсан явдал хүн төрөлхтний нэг том ололт, ан амьтныг хамгаалах ирээдүйтэй арга зам болжээ. Гэвч "шинэ газар эзэмших, ой мод ашиглах, хот суурин, үйлдвэр уурхай байгуулагдах явцад олон тооны зэрлэг араатан, жигүүртэн өөр нутагт дүрвэн, устах явдал ихэссээр байна." /3:14/ Зэрлэг ан амьтан бол хүнс тэжээлийн барагдашгүй, байнга нөхөн үйлдвэрлэгддэг амьд нөөц баялаг боловч сүүлийн хоёр зуу гаруйхан жилд дэлхийн шим мандлаас 150 зүйлийн жигүүртэн, 110 зүйлийн хөхтөн амьтад устсан, 600 гаруй зүйлийн ан амьтан сөнөхийн аюулд хүрээд байгааг судалгааны баримт тодорхой харуулж байгаа юм.

Ан амьтан бол байгалийн бүтээгдэхүүн, түүнийг ямагт чимэглэж сүр оруулж байдаг амьд үзмэр, үе дамжсан олон баг бүхий онцгой давхрага, хойшдоо ч байх ёстой онгон зэрлэг, омог догшин үнэт хишиг билээ. Гэвч хүмүүс ан амьтдыг үй олноор нь хомрогolon хядаж, арьс үс, мах, аль сортой болгоныг авах гэж түүхийн үе бүхэнд элдэв арга хэрэгслээр хайр найргүй хандаж ирсэн ажээ. Энэ бол нэг ёсондоо харалган үйл ажиллагаа, нөгөө талаар харгис үйлдэл байсан бололтой. Гэтэл манай дэлхий дээр байсан, одоо байгаа ан амьтан, өчүүхэн жижиг шумуулаас эхлээд хийморьлог догшин саарал чоно, хөвчийн хүрэн баавгай хүртэл харилцан шүтэлцээтэй, байгалийн нарийн тэнцвэрт харьцааг илэрхийлж байдаг онцлогтой гэнэ. Тухайлбал, зарим улс оронд чоныг устгаснаас болоод халдварт тахал өвчин гарч хүн амьтанд аюул учруулсан гашуун сургамж бий. Учир нь чоно бол амьд байгалийн санитарч, хүрээлэн буй орчны сэг зэмийг цэвэрлэн ариутгагч ажээ. Манай монголчууд чоныг хийморьтой, тэнгэрлэг амьтан гэж үздэг уламжлалтай учраас "ижил тэнгэртэйдээ харагдаж, илүү тэнгэртэйдээ алагддаг" хэмээдэг, чонын махыг хоол хүнсэндээ хэрэглэдэггүй, хүн төрлөө олдоггүй гэлцдэг. Гэвч чоныг шүтэхийн зэрэгцээ хар муу санаа, хашир байдлыг бас түүнтэй зүйрлүүлж үзэх, чоно хэт олширвол малын дайсан хэмээн "чонын хөөлгө" явуулж агнах явдал байв. "Шинэ нутагт буугаад мал сүрэгт чоно орохоос хамгаалж, хотоо тойруулж зурах, эрчтэй дээс хатааж зэллэх заншил одоо ч байна. Чонын амыг тэвхдсэн, хөлийг нь гинжилж тушсан зураг дармал даавуу, зурмал сийлмэл модон өнгө дүрс гэртээ дүүжилсэн айл мэр сэр тааралддаг." /4:540/

Манай орны нутаг дэвсгэрт олон төрлийн ан амьтан элбэг байдгаас тал хээр, говь тал хосолсон бүсэд цагаан зээр их байв. "Зээр бол амт сайтай мах, эдэлгээ сайтай илэгний үнэт түүхий эд өгдөг амьтан" /5:19/ учраас эртнээс хүмүүс түүнийг үлэмж агнаж иржээ. Энд илэгний үнэт түүхий эд гэсний учир нь ооны хүзүүний арьсыг голлож хэлсэн болов уу. Учир нь зээрийн арьсыг ширдэг дэвсгэр, хувцас өмсгөлд /Алтайн хоёр анчны тухай дуунд, зээрэн дээлтэй ахыгаа зэрвэс хараад намначихлаа гэж гардаг-Л.Ч./ ашиглахаас гадна оонын хүзүүний арьсыг элдэж уурганы маш бат бөх хуйв хийж байжээ. Цагаан зээрийн сүргээс эрийг нь түүж агнаснаас сүргийн бүтэц эвдэрч, улмаар тоо толгой нь цөөрөх, нутаг хавчигдан өөр тийш дүрвэн зайлах, бас бэлчээр ус дутагдаж үхэж хорогдох нь их болжээ. Иймээс бүр Х1Х зууны сүүл үеэс цагаан зээрийг хамаа

бус агнахыг хориглож, харин ч түүнийг малын бэлчээр сонгох “байгалийн бэлэн нэг чиг баримжаа” болгож ашиглаж байв. Миний бие дорнод тал хээрийн бүсэнд бэлчээр нутаг сонгох ардын уламжлалт мэдлэг ухааны талаар судалгаа хийх явцад цагаан зээртэй холбогдсон олон сайхан зүйлийг ахмад настнуудаас сонсож бүтээлдээ/6:94/ оруулсан билээ. Цагаан зээр бол улирлын байдлаар ус унд, бэлчээрээ даган хээрийн дов толгод, ам хөндий, тал газарт ихэвчлэн нутагшдаг, намрын улиралд сөл хөөж, өн болох нутагт байршин өвөлждөг ажээ. Өвлийн улиралд нутаглаж бүхий газарт цагаан зээр олноороо орж ирвэл тэр нутагт цаг тайван, өвөл өнтэй болох нь хэмээн малчид их бэлэгшээдэг байжээ. Зээр нь тухайн нутаг орны бэлчээрээс хамгийн сөл шим сайтай өвс ургамлыг олж иддэг учраас хашир туршлагатай малчид малын бэлчээрийг сонгож чадахгүй бол малаа дага, зээрийн нутгийг дага гэж сургамжилдаг байв. Гэтэл XX зууны үеэс хурдан унаа, галт зэвсэг элбэг болж, зээрийг ихээр агнаж, өнөө үед махыг нь ашиглах гэж олноор нь алж, тоо толгой нь үлэмж цөөрсөн байна. Цагаан зээр нь нөмөр дулаан газрыг сонгож хоноглодгоос гадна намар цагаан хяруу унахаар таргалдаг онцлогтой юм. Иймээс цагаан зээрийг хамгаалах тал бүрийн арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Монголчууд нүүдлийн аж ахуй эрхлэх явцдаа байгальтай ямагт харьцаж түүнд ойр байдаг болохоор ажиглалт туршилтын үндсэн дээр ардын мэдлэгийн арвин өв санг бүтээсэн ажээ. Ялангуяа ан амьтантай холбогдсон мэдлэг ухааны сургамжтай зүйл их юм. Тэдгээрээс зарим жишээ татвал, “гүйдлийн ан амьтан” хэмээн буга, тарвага зэргийг дурдаж болно. Эрт дээр үеэс монгол нутагт тарвага гэдэг амьтан тун элбэг байжээ. Тарваганы мах өөх, арьс үс их хэрэгцээтэй, бас тарвагаар цаг улирал, цас зудны байдлыг ч тодорхойлдог, зан үйлийн өвөрмөц ёсыг ч гүйцэтгэдэг байв. Мөн домч тарваганы тухай яриа үеэс үед дамжиж ирсэн нь санамсаргүй зүйл биш, өнөө үед ч анхаарахад илүүдэхгүй юм. Ардуудын ажиглалтаас үзэхэд, тухайн нутаг оронд тарваган тахал гарч болзошгүй нь зарим үед их тод илэрдэг гэнэ. Юуны өмнө тарвага хошгорохгүй, дошон дээрээ гүлдийн хэвтдэг, тэр үед нэг тарвага ойролцоох булаг, хужир мараа бүхий газар уруу гүйж, нойтон газар хөрвөөж үсээ норгоод, дараа нь хужир мараан дээр хөлбөрөн саарал болж буцаад явдаг ажээ. Тэр хужир марааг нь өвчилж эхэлж буй тарваганууд долоож илааршдаг байжээ. Ийм учраас малчид малдаа явахдаа богцонд хужир шүү хийж, ойр орчмын тарваганы дошон дээр бага багаар асгаж, тахал өвчнөөс өөрсдийгөө төдийгүй, ан амьтнаа хамгаалж ирсэн уламжлалтай. Энэ бүхний хүчинд мянга мянган жилээр тарвагатай нутагт оршин амьдарч ирсэн нүүдэлчид тарваган тахлаар өвчилж сүйрээгүй гэдэг. Түүхэнд бүр Х1Ү зууны үед европын 25 сая хүн тарваган тахлаар амь үрэгдэж, “хар тахал”-аас гадаадынхан сүнсээ зайлтал айдаг болсон тухай өгүүлсэн байдаг. Тарвагыг зүй зохистой агнавал их ач тустай, дээр үеэс тарвагыг “сайн эрийн ганзаганы чимэг, муу эрийн өдрийн зугаа” хэмээн хэлэлцэж ирсэн билээ. Зах зээлийн нөхцөлд тарваганы махыг хүнсэндээ хэрэглэх, арьсыг нь хэд гурван төгрөг болгохын тулд эр, эмгүй, хөгшин залуугүй зүтгэж, бас өвс ургамлын зүйлийн бүрэлдэхүүн ихээхэн өөрчлөгдсөн, бусад олон шалтгааны улмаас тарваганы тоо толгой ихээхэн цөөрч, одоохон хамгаалах дорвитой арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлэхгүй бол энэ амьтан устан “хар ном”-онд ороход тун дөхсөн бололтой.

Ер нь ан амьтанд хүний хайр ивээл үгүйлэгддэг жамтай, хүн хайрлаж чадвал хүний дэргэд ан амьтан сайхан байгаль хамт ивээлд нь багтдаг гэдгийг онцгой анхаарах, байгалиа өөд татахын тулд бололцоотой бүхнийг зориулах ёстой гэж үзэж байна. Энэ бол “хүн төрөлхтний байгалийн нууцын талаархи ойлголтоос байгаль өөрөө асар баян гэдгийг санавч бидний оюун ухаан түүний

өмнө хэзээ ч бууж өгөхгүй. Иймийн тулд бодол санаа хөгжмийн эгшиг лугаа цэвэр тунгалаг байж байгалийн нууц уруу дуудна”/7:17/ гэсэн эрдэмтдийн хүсэл эрмэлзлэлийг өөрийн эрхгүй санагдуулахын сацуу хүн байгалийн бүтээгдэхүүн хэдий ч түүнээс улам бүр холдож, авах нь өгөхөөсөө үлэмж их болсон учраас эцэст нь хүн төрөлхтөн орших уу, эс орших уу гэсэн үндсэн асуудалтай шууд холбогдож байгаа билээ.

Монголчууд дээр үеэс байгалийн баялагийг хайрлан хамгаалж гөрөөсний янзага, хурга, тарваганы мөндөл, гахайн торой хөнөөлтэй араатан амьтнаас бусад хөхүүл ан амьтныг алахыг цээрлэх /8:58/, мөн “онцгой өөр өнгөтэй чоно, тарвага, үнэг, өөр эвэртэй зээр гөрөөс агнах, зээрийн зэм авахыг хориглож” байжээ. Түүнчлэн “ан амьтдын хээлтэй байх буюу үр төл нь нялх үед авлах, ангийн махыг хөөдөх, бусдаас харамлахыг цээрлэдэг”/9:61/ “Эртнээс нааш манай анчид “олзыг олуулаа” гэдэг хууч үгийн ёсоор агнуурын олзворыг олноороо хийсэн юм гэж хавь ойрын хүмүүст ангийн махнаас түгээж хишиг болгон өгдөг заншилтай. Одоо ч тэр заншил хэвээр байдаг.”/10:92/ Энэ бүхнээс үзэхэд, эрт дээр үеэс монголчууд уламжлалт хорио цээрийн хэлбэрээр ангийн бичигдмэл биш хуулийг хатуу мөрдөж ан амьтдыг тодорхой хэмжээгээр хамгаалж, улмаар ХШ зууны үеэс хойшхи хуулиудад, ан амьтныг агнах, бас хамгаалах эрх зүйн үндсүүдийг тодорхойлон чанд дагаж биелүүлж иржээ. Зах зээлийн өнөөгийн нөхцөлд хууль, ёс журмыг чандлан мөрдөхийн зэрэгцээ уламжлалт хэв зан заншлыг ч алдагдуулахгүй байх нь байгаль хамгаалал, түүний дотор ан амьтныг хайрлан хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Монголын хууль цаазын бичигт, “сүм хийдийн дэргэдүүр бүү авла”, бас “хулан тахь бол/ албаас/ мориор тэргүүлсэн тавтаар, зээр, эр, эм гур /хандгай/ бол хониор тэргүүлсэн тавт, буга, согоо, бодон гахай бол үхрээр тэргүүлсэн тавт, тэх буга, ямаан гөрөөс /янгир/, хүдэр бол ямаагаар тэргүүлсэн тавт, элбэнх, дорго, тарвага зэрэгт хониор тэргүүлсэн тавт, арван туулайд нэг хонь, тавд нэг ямаа ав гэж заажээ. Монголчууд баавгайг шүтэж дээдлэхийн зэрэгцээ бугыг урт настай амьтан гэж үздэг учраас түүнийг албал нас буянд цөвтэй хэмээн буга алсан анчинг “нүгэлт хар гөрөөчин” хэмээн жигшдэг байв. Манай орон нутагт байгалийн хишиг болсон ан амьтныг хайрлах үзэл, сэтгэлгээ эртнээс түгээмэл байсны олон сайхан жишээг дурдаж болно. Тухайлбал, Лу гүн буга хамгаалах талаар айлдвар гаргаж, “Хан Хөхийн бугыг халтар халиун, яхир хар гэж ялгадаг. Яхир хар нь халтар халиунаасаа бие ба эвэр томтой, цээж өргөн, эршүү баргил дуутай, омголон догшин араншинтай, сүргийн сор, хангайнхаа чимэг гэхэд болохоор сайхан амьтан. Ийм давуу чанарыг мэдсэн хятад наймаачид их шунаж байгаа учир манай нутгаас Яхир буга дүрвэн нүүчихсэн гэж гадны хүнд хэлж байгтун. Бидний үед буга барагдахгүй. Гэхдээ ач, гуч, жичийнхээ баялагийг одооноос хайрлах учиртай”/11:120/ гэснийг албатууд нь ёсчлон биелүүлжээ. Малчин ардуудын дунд эртнээс уламжилж ирсэн үзлээр бол олон төрлийн хулганыг огт таашаадаггүй боловч үхэр огодой хэмээх дэлбэгэр чихтэй бор хулганыг ихэд эрхэмлэдэг, үхэр огодой гэрт орж ирвэл үхэр сүрэг өсөхийн бэлэгдэл гэдэг. Учир нь энэ амьтан хүнд гэм хор хүргэдэггүй, бэлчээрийн олон зүйлийн өвс ургамлаас 40 гаруй төрлийн шим сортойг түүвэрлэн хөөө хурааж, өвлийн үүцээ бэлтгэдэг ажээ. Иймээс тэр хөөөний гуравны хоёрыг малчид авч, үлдснийг нь үхэр огодойд орхидог уламжлалтай байжээ. Хэрэв хөөөгий нь бүрэн авчихвал хөөрхий хулгана идэш тэжээлгүй болно гэж үздэг. Энэ бол байгаль ан амьтныг хайрлан хамгаалж байсны нэг тод илрэл болой.

Монголчууд бас жигүүртэн, загасыг ч хамгаалах уламжлалт арга ухааныг үеэс үед дамжуулан өвлүүлж ирсэн юм. Тийм учраас шувууг хан хурмастын

амьтан хэмээн алах битгий хэл, өндгөн дээр нь сүүдрээ тусгахыг цээрлэж, шувууны хараал хүрнэ гэж үздэг байжээ. Ялангуяа тогорууны ангаахайг албал төмөр дөрөөний сэнж тасартал хараадаг гэж үр хүүхдүүддээ хэлдэг байв. Нүүдлийн шувуудыг урин дулаан цаг улирлыг авчирдаг гэж эрхэмлэн, "буцах шувуудыг гаран бүү хар, ирэх шувуудыг харан бүү ор гэсэн үг гарчээ." Монголчууд бас загасыг хайрлан хамгаалж, төрийн бэлэгдэл соёмбын голд залж хүндэлж ирсэн билээ. Иймээс саяхан болтол загасчлахыг төдийлөн таашааж үздэггүй байв. Загас бол хэзээ ч нүдээ цавчдаггүй, үр төл ихтэй, үржих төлжих нь нэн түргэн амьтан хэмээн дээдлэн бэлгэшээж, монгол эмэгтэйн ээмэг сүйх мэтэд хос загасны дүрс урлаж ирсэн байна" /12:87/

Дээр дурдсанаас үндэслэж, эрт дээр үеэс байгаль орчноо хамгаалах, ялангуяа ан амьтныг хайрлан хамгаалах талаархи монголчуудын уламжлалт мэдлэг ухаан, арга туршлагыг нэгэн бүхэллэг болгож судлах нь зөвхөн өнөө үеийнхэн төдийгүй, ойрын ирээдүйд ч танин мэдэх болон практик ихээхэн ач холбогдолтой гэж хэлж болно. Энэ нь хүмүүс байгалийн хууль зүй тогтлыг гүнзгий ухамсарлан ойлгож, байгалийн нууцад улам бүр нэвтрэн орж байгаа хэрэг мөний зэрэгцээ тэр хууль зүй тогтлыг ахуй амьдралдаа зохистой мөрдөх, байгалийн бэлэн баялаг хишгээс хүртэхийн сацуу хайрлан хамгаалж өгөөж үр шимийг нь бууруулахгүй байх ёстой гэсэн жам ёсны чиг хандлагыг илэрхийлж байна. Өнөө үед дэлхий дахинд хүн амын хүнс тэжээлийн асуудал анхаарал их татаж, экологийн цэвэр бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байгаа билээ. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх нэг эх булаг нь байгалийн бэлэн баялаг мөн боловч шавхагдашгүй нөөц гэж үзэхэд ихээхэн учир дутагдалтай болж бүхийг онцгой анхаарваас зохилтой. "Тус орны амьтны аймгийн хамгаалалтыг сайжруулах талаар нэлээд арга хэмжээ авч байна. Тухайлбал, төр засгаас ан амьтдыг дархан цаазтай болгох, тэдгээрийн идээшил нутгийг улсын тусгай хамгаалалтанд оруулах, хамгаалах, өсгөн үржүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээ авч ирлээ. Сүүлийн жилүүдэд зээр, тахь, минж зэрэг амьтад, зарим зүйлийн загасыг шинээр нутагшуулах, өсгөн үржүүлэх ажлыг хийж зохих амжилтанд хүрлээ. Харин олонхи судлаачид ан амьтныг шинээр нутагшуулахаас сэргээн нутагшуулах, төрөлх нутагт нь хамгаалж өсгөж үржүүлэх илүү ач холбогдолтой гэж үздэг." /13:61/ Монгол орны зэрлэг ан амьтныг ямар арга замаар, яаж үр дүнтэй хамгаалах нь зөв зүйтэй болохыг улиран өнгөрөх цаг хугацаа харуулах билээ.

Энэ бүхнээс үндэслэж, асуудлыг нягтлан тунгаах хэрээр бид дараах зарим санаа дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

Монгол орны зэрлэг ан амьтдыг хамгаалахын тулд юуны өмнө тэдгээрийг сайтар судлах, нэн ялангуяа байгаль цаг уурын өөрчлөлтийн нөхцөлд хэрхэн дасан зохицож буйг танин мэдэх явдал зайлшгүй чухал юм. Энэ нь байгаль хамгаалалын салбарт цаашид хэрэгжүүлэх төрийн бодлогыг боловсруулах хийгээд орон нутагт явуулах бүхий л ажил, арга хэмжээний тулгуур үндэслэл болно. Тухайлбал, Улаанбаатар хотын ойролцоох Богд ууланд амьдардаг бугын цус ойртсон, зэрлэг буга уулнаасаа бууж бараг хотын төв рүү, хүмүүс үрүү тэмүүлж буйг юу гэж үзэх бэ?

Манай улсад байгаль хамгаалал, түүний дотор ан амьтныг хайрлан хамгаалах менежментийг улам боловсронгуй болгох, удирдлага, зохион байгуулалтыг төгөлдөржүүлэх, техник технологиор сайтар хангах, орон нутгийн олон түмний хүч туслалцааг үр ашигтай хэлбэрээр авах, олон улсын зээл тусламжийг хэрэгжүүлэх төслийг санаачилан ажил хэрэгт нэвтрүүлэх зэрэг арга хэмжээ хэрэгтэй юм.

Зэрлэг амьтдыг үржүүлэхэд бага зардал шаардагдана. Тэднийг хэт асрамжилж дэндүү их шигүү байлгахгүй бол өөрөө тохируулах механизм

ажиллаж хүрээлэн буй орчны тайван байдалд ямар ч онцгой занал учрахгүй. Зэрлэг амьтад нь төлбөртэй ан агнуурын объект болж улсад болон эзэмшигчдэд нэмэлт орлого оруулна. Эцэст нь, хүн шинэчлэн өөрчлөөгүй байгалийн орчинд тэднийг үржүүлэх бололцоотой юм. Энэ нь экологийн ч, эдийн засгийн ч учир шалтгаанаар нэн чухал билээ./14:168-169/ гэж зарим эрдэмтэд бичиж байна. Манай орны хувьд өргөн уудам нутаг дэвсгэрт ан амьтдыг сэргээн нутагшуулах, тэр газрыг нь улсын тусгай хамгаалалттай болгох, байгаль экологийн унаган төрх, онгон байдлыг алдагдуулахгүй байлгахад онцгой анхаарвал зүйтэй мэт санагдана. Гэвч өнөө үед зарим аж ахуйн нэгж, хүмүүс алт эрдэнэс олборлох зорилгоор зэрлэг ан амьтад төдийгүй, орон нутгийн ард иргэдийн эдлэн газар уруу уухайлан дайрч, нөхөн сэргээлт хийхгүй орвонгоор нь эргүүлж, химийн хорт бодис их хэмжээгээр ашиглаж байгаа нь байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, хүн амьтан оршин байхад тун хэцүү нөхцлийг бүрдүүлж байна. Ийм зохисгүй байдлыг нэн даруй өөрчилж, зэрлэг ан амьтдаас дархлах, сэргээн нутагшуулах ажлыг гүнзгийрүүлэх нь манай оронд тэднийг үржүүлснээс нэг их дутахгүй ач холбогдолтой юм.

Ан амьтанд хүний хайр ивээл үгүйлэгддэг гэдгийг дээр бид тэмдэглэсэн. Зарим хүмүүс зэрлэг амьтдыг яаж хайрлах бэ гэж бодож байж болох юм. Манай зарим орон нутагт өвлийн улиралд зуд болох үеэр аргал, янгир зэрэг амьтдад зориулж зориуд өвс зөөж ууланд орхидог сайхан уламжлал бий. Тийм арга туршлагыг өнөө үед ашиглаж болохын зэрэгцээ техник технологи өндөр хөгжсөн учраас зудтай жилд зэрлэг амьтад бүхий газрын хөр цасыг ховхлож бэлчээр гаргах, боломж байвал нэмэгдэл тэжээл болох зүйл, хужир шүү тавьж өгөх, зуны хэт халалтын үед гол горхины усыг задгайлах, ан амьтдын бэлчээр нутгийг хавчихгүй байх зэрэг олон арга хэмжээ авч хэрэгжүүлж болно. Энэ бол хүмүүсийн санаачилга, хичээл зүтгэлээс шууд шалтгаалах боломжтой арга зам гэж хэлж болох юм.

Өнөө үед зэрлэг амьтдын ертөнцд бас их өөрчлөлт гарч байгааг анхаарах хэрэгтэй байна. Дэлхий дахинд ус цаг уурын өөрчлөлт өрнөж, үйлдвэржилт гүнзгийрэхийн хэрээр агаар орчны хордлого, бэлчээрийн өвс ургамлын шимт чанар ядуурч амьтад сайн тарга хүч авч чадахгүй болсон, энэ нь цаг хатуурч ирэхэд зүй бусаар хорогдох нэг шалтгаан болж байгаа билээ. Мөн зэрлэг ан амьтад янз бүрийн өвчин эмгэгтэй болж, ялангуяа халдварт өвчин тахал тохиолдоход ямар ч тусламж дэмжлэггүй олноороо үхэж хорогдож байна. Энэ байдлыг ихэнх хүмүүс байгалийн шалгарал явагдаж байхад хүмүүс бид хөндлөнгөөс нь яах билээ гэж үздэг. Гэтэл зэрлэг амьтдын эмгэнэлт хувь тавилан зөвхөн тэр хүрээндээ өрнөөд өнгөрөхгүй болсон тийм цаг үед бид аж төрж байна. Хэрэв зэрлэг амьтдын ертөнцд элдэв өвчин тахал гарвал тэр нь гэрийн тэжээмэл амьтдаар дамжин хүмүүст шууд нөлөөлөх болно. Иймээс дэлхийн үндэсний их дархан газарт зэрлэг амьтдыг хэрхэн хянаж, бас эмчилж эдгэрүүлж байгаа туршлага сургамжийг ч манай оронд харгалзан үзүүштэй. Энэ цаг үе холгүй гэж үзэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, дэлхий дээрх ан амьтдыг хайрлан хамгаалах явдал бол зөвхөн байгаль орчныг сонирхдог цөөн хэдэн хүний үүрэг биш, хүн төрөлхтөн өөрсдийгөө хүндэтгэн хамгаалж буй хэрэг, хүний гоо сайхны таашаалыг өрнүүлж бүхий үйл ажиллагаа гэж үзэж байна. Нүүдэлчид, түүний дотор монголчууд оршин амьдарч ирсэн байгаль, газар орон, ус, цаг уурын нөхцөлтэйгөө шууд хамааралтайгаар нүүдлийн аргаар эрхлэж буй мал аж ахуйн шинж чанартай холбогдож байгалиа, ан амьтнаа хайрлан хамгаалах өвөрмөц арга ухааны өв санг бий болгож иржээ. Энэ нь хэдэн мянган жилийн өмнөөс үүсэж, Хүннүгийн үеэс хойш үе дамжин уламжлагдаж, улам төгөлдөржин

боловсронгуй болсон ажээ.Энэ учраас өмнөх үеийн өв уламжлалыг хүндэтгэн дээдлэхийн зэрэгцээ өнөө үеийн ололтоор улам баяжуулж ашиглах,хойч үеийнхэндээ залгамжлуулах гол үүрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Abstract: The Mongols taboos and customs of environment ecology and conservancy have a huge amount of laws and closely related the customs of traditional household and pasturage. The "classic nomadic pasturage" is absolutely depends on climate and environment and has pantheist worships. Its roots caused by practice of ancient and modern pasturage. The "pyramid" of predator and prey existing on great steppe of Mongolia has main role animals, such as wolfs, marmots, antelopes and rodents and relations between those animals are real consequences of the Mongols taboos and customs.

Ашиглаж эш татсан ном зохиолын нэрс:

1. Монгол орны байгаль орчны хяналт-шинжилгээ: Газрын нөөц ба газрын нөөцийн менежмент Дэлхийн банк УБ.,2003
2. Монгол улсын түүх /Түүх,онол-арга зүйн асуудлууд/ УБ.,2006
3. С.Шатар,Д.Бурмаа.Ан амьтны өгөөж УБ.,1987
4. Х.Нямбуу,Д.Адьяасүрэн.Монгол ёс заншлын их тайлбар толь 1,УБ.,1992
5. С.Шатар,Д.Бурмаа.Дурдсан зохиол
6. Л.Чулуунбаатар.Бэлчээр нутаг сонгох малчдын уламжлалт арга ухаан, орчин үе /дорнод тал хээрийн бүсийн жишээн дээр/ диссертаци,УБ.,1993
7. Эртний амьтны сүүдэр УБ.,1974
8. Ц.Насанбалжир.Монголын аж ахуй хөтлөлтийн уламжлал,шинэтгэл /Х1Х зууны эцэс ХХ зууны эхэн/ УБ.,1978
9. И.Цоодол.Монгол ардын уламжлалт ёс,зан үйлийн дээж.1:2, УБ.,1991
10. Ж.Самбуу.Малчин ардын амьдрал ахуй,хэв заншлаас УБ.,1971
11. Х.Сампилдэндэв.Монгол домгийн чуулган УБ.,1999
12. Ж.Болдбаатар,С.Дэмбэрэл.Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил,хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн тойм "Түүх" ЭШБ,№ 188 /14/ УБ.,2002
13. Монгол орны байгаль орчин УБ.,1996
14. В.Дёжкин.Экологийн тухай яриа УБ.,1988